

Аудит хийх үндэслэл: Аудитыг Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 2 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/12 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын ерөнхий дүгнэлт: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол хийдэг боловч гэмт хэргийн гаралт буурахгүй байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байгааг харуулж байна.

**ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН ГЭМТ
ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГ
ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**



АГУУЛГА

Аудитын тайланг
бэлтгэсэн:

Төв аймаг дахь Төрийн
аудитын газар

Дарга, тэргүүлэх
аудитор

Ц.Хишигжаргал

Аудитын менежер
О.Амаржаргал

Аудитор
Ч.Загдсүрэн

2017 оны 10 дугаар
сарын 20

Уг тайланг АГ-ын Веб
сайтаас үзнэ үү.
www.tuv@audit.gov.mn

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70273463 дугаарын
утас, 70272582
дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ:

Төв аймгийн Төр
захиргааны 2 дугаар
байр

Товчилсон үгийн тайлбар.....4

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй,
шалгуур үзүүлэлт.....5-8

**БҮЛЭГ 1. Гэмт хэргээс урьдчилан
сэргийлэх ажлыг тогтмол хийдэг боловч гэмт
хэргийн гаралт буураагүй байна.**

1.1 Аймгийн хэмжээнд согтуугаар үйлдсэн
гэмт хэрэг, өмчлөх эрхийн эсрэг хулгайн гэмт хэрэг
нийт гэмт хэргийн дийлэнх хувийг эзэлж байгаа нь
газар нутгийн онцлогоос шалтгаалж
байна.....9-11

1.2 Аймгийн ИТХ-ын дэргэдэх ГХУСЗ нь жил
бүр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор
тодорхой зорилтууд, хэрэгжүүлэх арга
хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлж, жил бүрийн
төсөвтөө тодорхой хэмжээний санхүүжилтийг
батлан ажиллаж байна.....12-13

1.3 Цагдаагийн байгууллагаас давтан гэмт
хэрэг үйлдэхээс сэргийлэх зорилгоор хорих ял эдлээд
суллагдсан хүнд энэ хуульд заасан журмын дагуу
захиргааны хяналтыг тавьсан байна...13-15

1.4 Аймгийн ГХУСЗ, төрийн болон хууль
хяналтын байгууллагууд нь иргэд болон ТББ-тай
хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
чиглэлээр хамтран ажиллаж, зарим ТББ-дад
санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.....15-16

1.5 ГХУСАЗЗ-өөс жил бүр сургалт,
сурталчилгааны ажлын тасралтгүй байдлыг
хангаж ажилладаг бөгөөд хууль хяналтын
байгууллагууд нь гэмт хэргээс урьдчилан
сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг
иргэдэд мэдээлэх, сурталчилах, сургалтыг
тогтмол хийдэг байна.....16-17

**БҮЛЭГ 2. Гэмт хэргийн гаралт буурахгүй
байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ажлын арга хэлбэр өнөөгийн хэрэгцээ
шаардлагад нийцэхгүй байгааг харуулж байна.**

2.1 Гэмт хэргийн гаралт буурахгүй байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байгааг харуулж байна.....18

2.2 ГХУСА33 нь аймаг, сумын ИТХ-ын дэргэд орон тооны бус зөвлөл байгуулагдан хууль, хяналтын байгууллагуудтай хамтран өөрсдийн хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу ажиллаж байна.....18

2.3 Гэмт хэргийн гаралт буурахгүй байгаа нь анхан шатны нэгж болох сумын ГХУСА33 тодорхой ажил хийхгүй байгааг харуулж байна.....19

БҮЛЭГ 3.

3.1 ГХУС арга хэмжээнд 2015, 2016, 2017 онуудад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан хэмжээнээс дутуу төсөв баталсан байна.....20

3.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт сурталчилгаа, арга хэмжээ зохион байгуулсан боловч тодорхой үр дүнд хүрэхгүй байгаа нь төсөв, санхүүжилтийг бүрэн төлөвлөөгүйтэй холбоотой байна.....20-21

3.3 ГХУС арга хэмжээнд зарцуулагдсан хөрөнгийн ихэнхи хувийг сургалтын хоол, тэмцээн уралдааны шагналд зарцуулсан байна.....22-24

3.4 Аймгийн ИТХ-аас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлын зарцуулалтанд хяналт тавьсан талаар тайлан байхгүй байна.....25

Дүгнэлт.....26
Зөвлөмж.....27

Товчилсон үгийн тайлбар

ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ГХУС	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ГХУСАЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах зөвлөл
ТББ	Төрийн бус байгууллага
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ХХҮТ	Хөдөлмөр халамж үйлчилгээний төв
ОУБ	Олон улсын байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЭБАТ	Эрх бүхий албан тушаалтан
ХАСХОМ	Хувийн ашиг сонирхлын хөрөнгө орлогын мэдүүлэг
ХАСУМ	Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг
УБ	Улаанбаатар
АА	

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт**Аудитын зорилт:**

Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүнд аудит хийж, үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын гол зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараахь чиглэлээр аудит хийнэ. Үүнд:

- Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэх

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр үр дүнтэй эсэх

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдаж буй эсэх

Аудитын хамрах хүрээ:

Аудитад аймгийн Цагдаагийн газар, Прокурорын газар, аймгийн ИТХ болон бусад холбогдох төрийн байгууллагуудын 2015-2017 оны үйл ажиллагаа хамрагдана.

Үндсэн мэдээлэл:

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн зөвлөл нь 2015 онд дараахь тэргүүлэх зорилтуудыг дэвшүүлэн үйл ажиллагаагаа төлөвлөн сумдын зохицуулах зөвлөлүүдийг чиглүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатанд эрчимжүүлж, архины хамааралтай иргэдтэй ажиллах ажлыг сайжруулж, үр дүнд хүргэнэ.
2. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.
3. Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.
4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг эрчимжүүлнэ

Дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн зохицуулах зөвлөл 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 бүлэг 53 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр батлан ажиллав. Төлөвлөгөөний хэрэгжилт 12 дугаар сарын байдлаар 90%-тай хэрэгжсэн.

Аймгийн Зөвлөлийн төсвийг 20.200.000 /Хорин сая хоёр зуун мянга/-н төгрөгөөр батлуулж төсвийг төлөвлөгдсөн арга хэмжээнд зарцуулсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн зөвлөлийн хуралдааныг 2 удаа хуралдуулж, 9 асуудлыг хэлэлцэж 9 тогтоол батлан холбогдох байгууллагуудад хүргүүлэн хяналт тавьж ажилласан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн зөвлөл нь 2016 онд дараахь тэргүүлэх зорилтуудыг дэвшүүлэн үйл ажиллагаагаа төлөвлөн сумдын зохицуулах зөвлөлүүдийг чиглүүлэн ажиллалаа. Үүнд:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төр, захиргаа, хууль, хяналтын байгууллагын хамтын ажиллагааг сайжруулна.
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр дүнг дээшлүүлж, сумдын зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

Дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн зохицуулах зөвлөл 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 бүлэг 43 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр батлан ажиллав. Төлөвлөгөөний хэрэгжилт 2016 оны 12 дугаар сарын эхний байдлаар 80% -тай байна.

Аймгийн Зөвлөлийн төсвийг 39.928.000 /гучин есөн сая есөн зуун хорин найман мянга/-н төгрөгөөр батлуулж төсвийг төлөвлөгдсөн арга хэмжээнд зарцуулан ажиллаж, 33.665.000 мянган төгрөг зарцуулсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн зөвлөлийн хуралдааныг 2 удаа хуралдуулж, 13 асуудлыг хэлэлцэж 13 тогтоол, 2 тэмдэглэл батлан холбогдох байгууллагуудад хүргүүлэн хяналт тавьж ажиллаж байна.

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 63 дугаар тогтоолоор Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлаж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

Зөвлөл нь 23 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Зөвлөлийн даргаар Аймгийн ИТХ-ын дарга, Орлогч даргаар аймгийн Засаг дарга, Нарийн бичгийн даргаар аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Гишүүдээр: аймгийн ЗДТГ-ын дарга, аймгийн Цагдаагийн газрын дарга, Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, аймгийн Прокурор, аймгийн төрийн Аудитын дарга, Шүүх шинжилгээний албаны дарга, Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Хөдөө аж ахуйн газрын дарга, Эрүүл мэндийн газрын дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга, Тагнуулын хэлтсийн дарга, ШШГА-ны дарга, Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой байдлын газрын дарга, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга, Ахмадын холбооны дарга, Эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга, Залуучуудын холбооны дарга, Архидан согтуурахтай тэмцэх ТББ-ын тэргүүн, Олон нийтийн телевизийн захирал гэсэн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн зөвлөл нь 2017 онд дараах тэргүүлэх зорилтуудыг дэвшүүлэн үйл ажиллагаагаа төлөвлөн сумдын зохицуулах зөвлөлийг үүрэг чиглэл, арга зүйн зүйн зөвлөмжөөр ханган ажиллалаа.

Үүнд:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төр, захиргаа, хууль хяналт болон мэргэжлийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулна.
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр дүнг дээшлүүлж, сумдын зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.

Дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн зохицуулах зөвлөл 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 бүлэг 64 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр батлан төлөвлөгөөний хэрэгжилтийн явц 50%-тай байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн зөвлөлийн хуралдааныг 3 удаа хуралдуулж, 15 асуудлыг хэлэлцэж 12 тогтоол, 2 тэмдэглэл, 1 зөвлөмж, 1 уриалгыг батлан холбогдох байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.

2017 оны эхний хагас жилийн байдлаар Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хүрээнд хууль, эрх зүйн хэлэлцүүлэг, эрхзүйн сургалт сурталчилгаа, УИХ-аас шинээр батлагдан гарсан хууль, тогтоомжийн танилцуулга зэрэг арга хэмжээг 27 сумдад давхардсан тоогоор 34 удаагийн сургалтаар 4525 иргэн, ААНБ-ыг хамруулан ажиллалаа.

Тайлант хугацаанд нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр уулзалт-17, нэгдсэн зөвлөгөөн-3, аян-6, хэсэгчилсэн болон нэгдсэн арга хэмжээ-35 гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 61 удаагийн олон талт арга хэмжээг Хууль хяналтын байгууллага болон иргэд, олон нийтийн оролцоонд түшиглэн хамтран зохион байгуулж ажиллалаа.

Аймгийн Зөвлөлийн 2017 оны төсвийг 33.111.4 /гучин гурван сая нэг зуун арван нэгэн мянга дөрвөн зуун/ төгрөгөөр батлуулж эхний хагас жилийн байдлаар 10.045.6 / Арван сая дөчин таван мянга зургаан зуун мянга/ төгрөгийг зарцуулсан байна.

Эрсдлийн үнэлгээ:

Урьдчилсан судалгааны явцад хийсэн дүн шинжилгээ, харилцан ярилцлагад үндэслэн ерөнхий эрсдлийг “дунд” гэж үнэлэв.

Аудитын арга зүй:

Аудитын явцад холбогдох албан тушаалнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглахаас гадна Аудитын дээд байгууллагын олон улсын стандар, гүйцэтгэлийн аудитын журамд дурдсан аудитын арга зүйг мөрдөж аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараахь хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана.

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль,
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх журам
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр
- Цагдаагийн албаны тухай хууль
- Прокурорын тухай хууль
- Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль
- Захиргааны хариуцлагын тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль
- Замын хөдөлгөөний дүрэм
- Иргэний хууль
- Эрүүгийн хууль
- Прокурорын байгууллагын тухай хууль
- Гэр бүлийн тухай хууль

- Гэр бүлийн хүчирхийлэлийн тухай хууль
- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөрийн төлөвлөгөө

Аудит хийх бүрэлдэхүүн: Аудитыг аймгийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал удирдан, аудитор Ч.Загдсүрэн хийж гүйцэтгэв.

Аудитын хугацаа:

Аудитыг 2017 оны 09 дүгээр сарын 10-нд эхэлж, 10 дугаар сарын 23-ний өдөр хүргүүлнэ.


Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж байна уу?

Бүлэг 1

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол хийдэг боловч гэмт хэргийн гаралт буураагүй байна.

1.1 Аймгийн хэмжээнд согтуугаар үйлдсэн гэмт хэрэг, өмчлөх эрхийн эсрэг хулгайн гэмт хэрэг нийт гэмт хэргийн дийлэнх хувийг эзэлж байгаа нь газар нутгийн онцлогоос шалтгаалж байна.


Төв аймаг нь Нийслэл Улаанбаатар хотыг тойрсон байршилтай, нийт 74.8 мянган км/кв нутагтай, газар нутгийн 16.4 хувийг ойн бүс, 36.5 хувийг тал хээрийн бүс эзэлдэг. Засаг захиргааны 27 сум, 103 баг, 90.0 мянган хүн ам, 28084 га талбай ашигт малтмалын газартай, 37 Ерөнхий боловсролын сургууль, 5 Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, 3.6 сая толгой мал, 14.0 мянган тээврийн хэрэгсэлтэй, хүн амын төвлөрөл, суурьшил ихтэй, авто замын сүлжээ өргөн хөгжсөн, Сэлэнгэ, Хэнтий, Говьсүмбэр, Дундговь, Өвөрхангай, Булган зэрэг аймгуудтай хил залгаа, Улаанбаатар хотруу дамжин өнгөрөх улсын чанартай хатуу хучилттай нийт 1500 орчим км зам дамжин өнгөрдөг. Аймгийн төвөөсөө хамгийн ойр сум нь 14 км, хамгийн хол бөгөөд алслагдсан сум нь 261 км зайтай байрладаг. Тус аймаг нь газар нутгийн онцлог, хүн амын суурьшил, улсын чанартай авто зам, төмөр зам өргөн хөгжсөн, улсын чанартай бүтээн байгууллалтын ажил ихээр явагддаг үүнийгээ дагаад хүн амын төвлөрөл нэмэгддэг, отор нүүдэл ихтэй, зэрэг олон шалтгаан нөхцлөөс шалтгаалан эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал бусад аймгуудаас хүнд байдаг. 2017 оны эхний хагас жилийн байдлаар:



Аймгийн цагдаагийн газраас аймаг орон нутгийн хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдалд судалгаа, дүгнэлт хийж, шалтгаан нөхцлийг судлан газар нутгийн онцлог, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуудлан тодорхой төрлийн гэмт

хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой зохион байгуулахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилласан байна. Тухайлбал: 27 сумын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийг сум тус бүрээр нь шалтгаан нөхцлийг нь судлан дүгнэж тухайн сум, орон нутгийн удирдлагууд болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд улирал бүр зөвлөмж, ажлын чиглэл хүргүүлж хамтран ажилласан байна. Мөн 27 сумыг 8 бүс болгон алба хаагчдыг багаар хуваарилан хариуцсан бүсийн ахлагч нарт тухайн сум орон нутаг руу чиглэсэн ажил арга хэмжээг зохион байгуулах талаар заарварчлага өгч үр дүнг тооцон ажиллажээ.

Аймгийн нутаг дэвсгэрт үйлдэгдэж байгаа гэмт хэргийн дийлэнх хувийг бусдын эд хөрөнгийг хулгайлах, иргэдийн эрүүл мэнд эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах журмын эсрэг гэмт хэргүүд тодорхой хувийг эзэлж байдаг. Сүүлийн жилүүдэд Байгаль орчны эсрэг гэмт хэрэг, Ойн тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэргүүд нэмэгдэх хандлагатай байгаа.



Хэдийгээр цагдаагийн газраас хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр эргүүл хяналт шалгалт, анхааруулга сэрэмжлүүлэгийг хүргэж байгаа хэдий ч энэ төрлийн гэмт хэргийн гаралт өсч байна.

Аймгийн Прокурорын газар нь “Аймгийн эрүүгийн нөхцөл байдал, эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилт”-ийн талаар хагас, бүтэн жилээр аймгийн ИТХ-д мэдээлэл хүргүүлж ажилласан байна. Мөн “Гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулах прокурорын мэдэгдэл”-ийг 2015 онд 68, 2016 онд 107, 2017 оны эхний хагас жилийн байдлаар 40-ийг бичиж, хариуг хуулийн хугацаанд авч биелэлтийг тооцож ажилласан байна. Жишээлбэл: аймгийн Прокурорын байгууллагаас ирүүлсэн судалгаагаар 2017 оны эхний хагас жилийн байдлаар бичигдсэн 40 мэдэгдлийн 8 нь хулгайн, 6 нь согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн мэдэгдэл байна.

Гэмт хэргийн тоон мэдээ, судалгаанаас харахад аймгийн хэмжээнд согтуугаар үйлдсэн гэмт хэрэг, өмчлөх эрхийн эсрэг хулгайн гэмт хэрэг тэр дундаа

малын хулгайн гэмт хэрэг, дээрмийн гэмт хэрэг 2017 онд өмнөх оны мөн үеэс өссөн байгаа нь дараах хүчин зүйлсээс шалтгаалж байна гэж үзэж болохоор байна.

- Газар зүйн байрлалын хувьд Нийслэл Улаанбаатар хоттой ойрхон тул бүлэг этгээдүүд шөнөдөө УБ хотоос машинтай гарч хээр малыг бэлчээрт нь нядлаад үүрээр хот руу орж хүнсний захуудад бөөндөж махыг нь худалдаалах
- Суурин сум, орон нутгийн иргэдээс илүү хаана оршин суудаг хэн гэдэг нь тодорхойгүй этгээдүүд энэ төрлийн гэмт хэргийг илүү үйлдэж байна.

Төв аймгийн хэмжээнд **2015 онд** 863 гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 88 нэгжээр буюу 9.7 хувиар буурч, гэмт хэргийн илрүүлэлт 63.5 хувь ба өмнөх оны мөн үеэс 6.8 хувиар өссөн. Гэмт хэргийн ангилалаар нь авч үзвэл: Хөнгөн гэмт хэрэг 9.7%, хүндэвтэр гэмт хэрэг 10.2%, хүнд гэмт хэрэг 10.8 хувь, онц хүнд гэмт хэрэг 13.3 хувиар тус тус буурсан байна. Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал: Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 10.9%-иар буурсан байна. Нийт гэмт хэргийн 45.7 хувийг иргэдийн өмчийн хулгай, 27.8 хувийг иргэдийн эрүүл мэнд, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг, 14.3 хувийг зам тээврийн осол хэрэг эзэлж байна. Гэмт хэргийн улмаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагад 3.1 тэрбум төгрөгний хохирол учирч, 66 хүн нас барж, 367 хүн гэмтсэн байна.

2016 онд 812 гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 51 нэгжээр буюу 5.9 хувиар буурч, хэргийн илрүүлэлт 63.7 хувь ба өмнөх оноос 42 нэгжээр буюу 21 хувиар буурсан байна. Хөнгөн гэмт хэрэг 334, хүндэвтэр гэмт хэрэг 418, хүнд гэмт хэрэг 47, онц хүнд гэмт хэрэг 13 тус тус бүртгэгдсэн байна. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 224 буюу 19.2%-иар өсч, бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 51 буюу 1.9% буурч, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг 43 буюу 10.4 хувиар буурсан байна. Нийт гэмт хэргийн 36.6 хувийг иргэдийн өмчийн хулгай, 28.7 хувийг иргэдийн эрүүл мэнд, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг, 14.9 хувийг зам тээврийн осол хэрэг эзэлж байна. Гэмт хэргийн улмаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагад 3.5 тэрбум төгрөгний хохирол учирч, 113 хүн нас барж, 366 хүн гэмтсэн байна.

2017 оны эхний 9 сарын байдлаар 700 гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 49 нэгжээр буюу 7.5 хувиар өссөн, хэргийн илрүүлэлт 28.3 хувь ба өмнөх оноос 17 нэгжээр буюу 13.6 хувиар буурсан байна. Хөнгөн гэмт хэрэг 395, хүндэвтэр гэмт хэрэг 210, хүнд гэмт хэрэг 92, онц хүнд гэмт хэрэг 3 тус тус бүртгэгдсэн байна. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 110 буюу 33.3%-иар буурч, бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 2 буюу 5.3% өсч, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг 5 буюу 15.6 хувиар буурсан байна. Нийт гэмт хэргийн 42.7 хувийг иргэдийн өмчийн хулгай, 22.7 хувийг иргэдийн эрүүл мэнд, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг, 13.3 хувийг зам тээврийн осол хэрэг эзэлж байна. Гэмт хэргийн улмаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагад 3.0 тэрбум төгрөгний хохирол учирч, 103 хүн нас барж, 241 хүн гэмтсэн байна.

Гэмт хэргийн тоон мэдээ, судалгаанаас харахад аймгийн хэмжээнд согтуугаар үйлдсэн гэмт хэрэг, өмчлөх эрхийн эсрэг хулгайн гэмт хэрэг нийт гэмт хэргийн дийлэнх хувийг эзэлж байгаа нь газар нутгийн онцлогоос шалтгаалсан гэж үзэж болохоор байна.

1.2 Аймгийн ИТХ-ын дэргэдэх ГХУСА33 нь жил бүр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор тодорхой зорилтууд, хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус аймгийн хэмжээний эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал нь бусад аймгуудтай харьцуулахад хүнд юм. Энэ нь газар нутгийн онцлог, хүн амын суурьшил, авто машины дамжин өнгөрөх хөдөлгөөн, нягтрал ихэссэн, шилжилт хөдөлгөөн, ажилгүйдэл, архидалт, бусад аймаг хот дамжин өнгөрөх улсын чанартай авто зам, төмөр зам өргөн хөгжсөн, улс, аймгийн чанартай бүтээн багуулалтын ажил ихээхэн явагдаж байгаа зэрэг олон хүчин зүйлүүдээс шалтгаалан гэмт хэргийн гаралт их байдаг. Иймээс гэмт хэргийг үйлдэгдсэн хойно нь биш, үйлдэгдэхээс нь өмнө урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулахад анхаарах шаардлагатай байдаг.

Мөн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн зөвлөл нь жил бүр тухайн онд хэрэгжүүлэх тэргүүлэх зорилтуудыг дэвшүүлэн үйл ажиллагаагаа төлөвлөн сумдын зохицуулах зөвлөлүүдийг чиглүүлэн ажилласан байна.

2015 онд: 1.Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатанд эрчимжүүлж, архины хамааралтай иргэдтэй ажиллах ажлыг сайжруулж, үр дүнд хүргэх,

2.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх,

3.Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх

4.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх гэсэн зорилтуудын хүрээнд 53 арга хэмжээг хэрэгжүүлэхээр

2016 онд: 1.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төр, захиргаа, хууль, хяналтын байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах ,

2.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр дүнг дээшлүүлж, сумдын зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилтуудын хүрээнд 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр

2017 онд: 1.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төр, захиргаа, хууль хяналт болон мэргэжлийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах,

2.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр дүнг дээшлүүлж, сумдын зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх,.

3.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх гэсэн зорилтуудын хүрээнд 64 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулж ажилласан байна.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх ГХУСА33 нь жилдээ 2-4 удаа хуралдаж ажлаа дүгнэн, дараа оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон төсвөө батлах, холбогдох тогтоол шийдвэрийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн хяналт тавьж ажиллаж байна.

Аймгийн ГХУСА33 нь сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны хэвийн тасралтгүй ажиллагааг хангаж, орон нутагтаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэн, аймгийн зохицуулах зөвлөлөөс хийсэн шалган туслах ажлын дүнгээр “Хангалттай”

үнэлгээ авсан сумдыг байр эзлүүлж, Архи хэрэглэдэггүй байгууллага өрх шалгаруулах, Тэргүүний хуульч, Тэргүүний малчдын бүлэг шалгаруулах, Гэмт хэрэг, хэв журмын зөрчилгүй сургууль шалгаруулан, мөнгөн шагналаар урамшуулж, “Архидалтын эсрэг Төв аймаг” хөтөлбөрийн хэрэгжилт, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Цагдаагийн газраас зохиож байгаа ажлын талаарх мэдээллийг хэлэлцэж тогтоол, шийдвэр гаргасан байна.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх ГХУСАЗЗ нь жил бүр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор тодорхой зорилтууд, хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлж, жил бүрийн төсөвтөө тодорхой хэмжээний санхүүжилтийг батлан ажиллаж байна.

1.3 Цагдаагийн байгууллагаас давтан гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх зорилгоор хорих ял эдлээд суллагдсан хүнд энэ хуульд заасан журмын дагуу захиргааны хяналтыг тавьсан байна.

Төв аймгийн хэмжээнд 2015 онд нийт 177 ялтан, 2016 онд нийт 108 ялтан, 2017 оны хагас жилийн байдлаар 169 ялтанд захиргааны хяналт тогтоосон шүүхийн тогтоолыг зохих газарт хүргүүлж, захиргааны хяналт тавин ажилласан байна. Үүнээс хорих ял эдлээд хугацааны өмнө тэнсэн суллагдсан 2015 онд 44, 2016 онд 39, 2017 онд 27 хүнд давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд цагдаагийн байгууллага захиргааны хяналт тогтоож ажилласан байна. Тухайлбал: Цагдаагийн байгууллагаас захиргааны хяналтанд авагдсан этгээдийн мэдээллийг цагдаагийн байгууллагын нэгдсэн мэдээллийн санд оруулж, гар хурууны хээг шүүх шинжилгээний албаны гарын хээний папилон санд оруулж, хяналтанд авагдсан өдрөөс эхлэн прокурорын хяналтанд давхар авч, тухайн этгээдэд хилийн хориг тавиулж ажиллажээ. Захиргааны хяналтыг сайжруулах, хяналтанд байгаа этгээдүүдийг дахин гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулснаар сүүлийн жилүүдэд хяналтанд байгаа этгээдүүдээс дахин гэмт хэрэгт холбогдох нь буурсан.

Цагдаагийн байгууллагаас давтан гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх зорилгоор хорих ял эдлээд суллагдсан хүнд энэ хуульд заасны дагуу захиргааны хяналтыг тавьсан байна.

1.4 Аймгийн ГХУСАЗЗ болон хууль хяналтын байгууллагууд нь иргэд, ТББ-тай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллаж, зарим ТББ-дад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.

ГХУС тухай хуулийн 12 дугаар зүйлд иргэд аж ахуйн нэгжийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах талаар Нутгийн захиргааны байгууллага хэрэгжүүлэхээр заажээ.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 03-р сарын 06-ны өдрийн хуралдаанаар аймгийн Цагдаагийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг бүхий Иргэний зөвлөлийн гишүүдийг томилж, тэдний урамшуулалыг тогтоон батласан байна. Аймгийн Иргэний зөвлөл нь аймгийн Цагдаагийн газартай хамтран Зуунмод сумын иргэдийг төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх нэрээр залилан мэхлэх ажиллагааг таслан зогсоох, арга хэмжээ авахуулах, Зуунмод сумын гэмт хэргээс

урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран өршөөлийн хуулиар суллагдсан иргэдийг хүлээн авч зөвлөгөө өгөн, мэдээллээр ханган ажиллажээ.

Аймгийн Цагдаагийн газраас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн, аж ахуйн нэгж байгууллагын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр “Амар тайван амьдралын төлөө хамтдаа” аялах дэвтрийг баг, хороо, аж ахуйн нэгж байгууллагуудаар аялуулах, иргэдийн сайн дурын эргүүл, урамшилтай эргүүл, нийтийн эргүүл зэрэг олон нийтийг хамарсан ажлуудыг тогтмол зохион байгуулдаг байна. Жил бүр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвх санаачлагатай ажилласан малчдын бүлэг, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, иргэдийг Цагдаагийн газрын баярын бичиг болон сум, багийн ГХУСАЗЗ-тэй хамтран шагнаж урамшуулдаг байна. 2015-2016 онд нийтийн эргүүлд 86 байгууллагын 160 гаруй иргэнийг татан оролцуулж, 2017 онд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр “Урамшилт эргүүл”, “Нийтийн эргүүл” арга хэмжээнүүдийг зохион явуулжээ. Тухайлбал: Сар шинийн баярын үеэр аймгийн бүх шатны байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтан, албан хаагчид, иргэдийг оролцуулан “Нийтийн эргүүл” нэг сарын аяныг зохион байгуулж арга хэмжээний хүрээнд 150 гаруй байгууллага аж ахуйн нэгжийн 530 гаруй ажилтан албан хаагчдыг нийтийн эргүүлд ажиллуулсан байна. Мөн цагдаагийн байгууллага, эцэг эх, боловсролын байгууллагын ажилтан албан хаагчдын оролцоог дээшлүүлэх зорилгоор хичээлийн жилд аймаг орон нутгийн ерөнхий боловсролын сургуулиудтай хамтран ажиллах чиглэлээр Зуунмод сумын таван сургуулийн захирал, эрхлэгч нартай гэрээ байгуулж сургуулийн ойр орчинд хүүхдийг зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх болон хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор “SCHOOL POLICE” эцэг эхийн эргүүлийг тогтмол ажиллуулж хэвшснээр сургуулийн орчинд үйлдэгдэх хэрэг, зөрчил буурсан байна.

2008 оноос хойш аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн төлөвлөгөөнд “Тэргүүний мал хамгаалах бүлэг”-г оны эцэст шалгаруулж хэвшсэн байна. 2017 онд малчдын бүлгийн ажиллах журмыг аймгийн ИТХ-аар шинэчлэн батлаж малчдын бүлгүүдэд тарааж хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

Мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн зөвлөлөөс зарим ТББ-уудтай хамтран ажиллаж, санхүүгийн дэмжлэг үзүүлжээ. Тухайлбал:

2015 он, 2016 онуудад “Архидалтын эсрэг Төв аймаг хөтөлбөр”-ийн хүрээнд архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Оюунлаг өөрчлөлт” ТББ-д үйл ажиллагаанд нь зориулж нийт 4 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, Баянчандмань, Борнуур, Сүмбэр, Жаргалант суманд архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр өдөрлөг уулзалтыг Монголын гэр бүлийн хөгжлийн сайн сайхны нийгэмлэг, Дэлхийн Зөн Олон улсын байгууллага, аймгийн Прокурорын газар, аймгийн Эрүүл мэндийн газар, аймгийн Халамж үйлчилгээний хэлтэс, сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл зэрэг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж өдөрлөг уулзалтанд 2158 иргэнийг хамруулж, анхааруулга, сэрэмжлүүлэг тараах материал тараасан, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэдэг 12 иргэний ар гэрийн хүмүүстэй нь уулзан сэтгэл зүйн зөвлөгөө өгөн 4 иргэнийг дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран хордлого тайлах эмчилгээнд хамруулах зэрэг ажлуудыг хийсэн байна.

2016 онд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн зөвлөлөөс аймгийн “Ахмадын хороо”, “Оюунлаг өөрчлөлт”, “Эмэгтэйчүүдийн зөвлөл” ТББ-тай хамтран ажиллах гэрээ байгуулан, гэрээнд тусгагдсан ажлыг

хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэж 4.6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

2017 онд ЭМГ, Зуунмод сумын ЗДТГ, ХХҮГ, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Дэлхийн зөн ОУБ зэрэг байгууллагатай хамтран “Архидалтын эсрэг-Төв аймаг” хөтөлбөрийн үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор архины хамааралтай, архинд донтох өвчтэй Зуунмод сумын 10 иргэнийг “Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв”-ийн сайн дурын өдрийн эмчилгээ, сургалтанд хамруулсанаас 7 иргэнийг архины хамаарлаас гаргах, сэтгэл заслын эмчилгээ болон хувь хүний төлөвшил, зан байдлыг өөрчлөх Дэлхийн зөн ОУБ-ын вакумжуулсан сургалт, мэргэжил олгох болон давтан сургалтанд тус тус хамруулж, нийгэмшүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлж байна.

Аймгийн ГХУСАЗЗ, төрийн болон хууль хяналтын байгууллагууд нь иргэд болон ТББ-тай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллаж, зарим ТББ-дад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.

1.5 ГХУСАЗЗ-өөс жил бүр сургалт, сурталчилгааны ажлын тасралтгүй байдлыг хангаж ажилладаг бөгөөд хууль хяналтын байгууллагууд нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг иргэдэд мэдээлэх, сурталчилах, сургалтыг тогтмол хийдэг байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс жил бүр сургалт, сурталчилгааны ажлын тасралтгүй байдлыг хангаж ажилладаг байна. Үүнд: сумдын зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга, цагдаагийн хэсгийн төлөөлөгч нарт мэргэжил арга зүйн сургалтыг жил бүр зохион байгуулдаг байна.



2015 онд Хууль зүйн яам, Хүний эрхийн үндэсний комисс, Авлигатай тэмцэх газартай хамтарсан сургалт, аймгийн төвд 2 зөвлөгөөн, сумдын бүсийн өдөрлөг, сургалтыг иргэд байгууллага руу хандсан сургалт сурталчилгааг 16 удаа хийж 18000 гаруй иргэдийг хамруулж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар мэдлэг, мэдээлийг хүргэсэн байна. Мөн 27 сумын зохицуулах зөвлөлүүд нь иргэд, байгууллагуудад чиглэсэн сургалт сурталчилгааг давхардсан тоогоор 130 удаа хүргэж 25000 гаруй иргэдийг хамруулжээ.

2016 онд 3 удаагийн нэгдсэн сургалтыг зохион байгуулж, Аймгийн ИТХ-ын Ажлын алба, Нутгийн удирдлага, хууль хяналт, гадаад харилцааны хороо, Зуунмод сумын ИТХ-ын Ажлын алба, Хууль зүйн хэлтэстэй хамтран аймгийн төв болон 26 сумын худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн дунд аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхэд хяналт тавих, тусгай зөвшөөрөл олгох шинэчилсэн журмын талаар хэлэлцүүлэг зохион байгуулж, 900 гаруй иргэн, худалдаа үйлчилгээ эрхлэгчид, төрийн байгууллагын албан хаагчид оролцож, хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан 266 иргэн санал, хүсэлт, дүгнэлтээ гаргаж илэрхийлсэн байна.

“Архидалтын эсрэг Төв аймаг хөтөлбөр”-ийн хүрээнд архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Оюунлаг өөрчлөлт” ТББ 14 сумын 280 иргэдэд “Архины хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх тухай” цуврал ярилцлага, сургалт, мөн түүнчлэн ЕБС-ийн нийт 1330 сурагчдад “Архигүй нийгмийн ирээдүй” сэдэвт сургалтуудыг тус тус зохион байгуулжээ. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, олон нийтэд гэмт хэрэг, зөрчлийн хор уршгийг сурталчлан таниулах ажлын хүрээнд мэргэжлийн байгууллагатай хамтран аймгийн төвд сурталчилгааны самбартай болсон, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэдэг гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг иргэдийг Зуунмод сумын тамгын газар, Дэлхийн Зөн олон улсын байгууллагатай хамтран баг бүрт “Эрүүл баяр хөөртэй гэр бүл” сургалт, Монголын АА нийгэмлэгтэй хамтран Зуунмод суманд согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэдэг 28 иргэнд сургалт зохион байгуулсан байна.

2017 оны эхний хагас жилийн байдлаар Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хүрээнд хууль, эрх зүйн хэлэлцүүлэг, эрх зүйн сургалт сурталчилгаа, УИХ-аас шинээр батлагдан гарсан хууль, тогтоомжийн танилцуулга зэрэг арга хэмжээг 27 сумдад давхардсан тоогоор 34 удаагийн сургалтаар 4525 иргэн, ААНБ-ыг хамруулсан байна. Төв аймгийн Прокурорын газар болон Хууль, эрх зүйн хэлтсээс зохион байгуулж байгаа хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлын хүрээнд албан хаагчдад эрх зүйн мэдээлэл хүргэх, тэдний эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийн талаар сургалтыг “Хүчирхийллийн эсрэг Үндэсний төв” ТББ-тэй хамтран зохион байгуулсан байна. Мөн хоригдогч ялтануудыг соён гэгээрүүлэх, хийсэн үйлдэлдээ гэмших ухамсарыг төлөвшүүлэх, хорих ялаа дуусгаад эргэн нийгэмшихэд нь туслах зорилгоор нийт давхардсан тоогоор 9 удаагийн сургалт хүмүүжлийн ажлыг Төрийн болон Төрийн бус байгууллагуудтай хамтран Авдрант, Майнтын хорих ангийн 1200 гаруй ялтаныг хамруулан зохион байгуулжээ. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр, агентлаг, байгууллагын ЭБАТ-уудад, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх, сурталчлах сэдвээр, жил бүр зохион байгуулдаг 27 сумдын ЗДТГ-ын дарга бөгөөд ЭБАТ хариуцсан мэргэжилтнүүдэд “ХАСХОМ”, “ХАСУМ”, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх нь” сэдвээр нэгдсэн сургалт, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар Зуунмод сумын ЗДТГ-ын албан хаагч, цэцэрлэг, сургуулийн удирдах албан тушаалтан, нягтлан бодогч нарыг хамруулан давхардсан тоогоор нийт 7 удаагийн сургалтыг 290 гаруй албан хаагчийг хамруулан сургалт, сурталчилгаа соён гэгээрүүлэх ажлыг хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байна.

Аймгийн Цагдаагийн газрын Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд WWW.stop.mn, tuv.police.gov.mn, “Төв аймаг дахь Замын цагдаагийн тасаг” Цахим хуудсаар, Төв аймгийн замын цагдаагийн тасаг, Баянчандмань замын цагдаагийн хэсэг, Лүн лүн гэсэн 3 facebook хаягаараа дамжуулан зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, замын зохион байгуулалтын чиглэлээр хийсэн ажил, цаг агаарын нөхцөл байдал, нутаг дэвсгэртээ зохион байгуулж байгаа арга хэмжээнүүдийг тогтмол танилцуулж дамжуулан шинэчлэн батлагдсан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”-ийг иргэд, албан байгууллага олон нийтэд Зуунмод сумын “ТBS” телевизээр 7 хоног бүр сургалт сурталчилгааг явуулж, олон нийтийн санал хүсэлтийг хүлээн авч, “ТBS” телевиз, Монгол туургатан театрын уран бүтээлч нартай хамтарч зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх талаар зохиомж нэвтрүүлэг хийж, телевизээр ард иргэдэд үзүүлсэн байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн зөвлөлөөс зохион байгуулсан ажилд өөрийн чиг үүргийн хүрээнд ажилд идэвх санаачлагатай ажиллаж, иргэд, олон нийтийн дунд урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, яриа таниулгыг тогтмол сайн явуулж ажилласан шүүгч, аймгийн Цагдаагийн газар, ШШГАлбаны ажилтан, сумын ЗДТГ-ын хууль эрх зүйн мэргэжилтэн нарыг жил бүр “Оны Тэргүүний хуульч”-аар өргөмжилж, мөнгөн шагналаар урамшуулдаг байна.

Мөн аймгийн Прокурорын газрын жилийн ажлын төлөвлөгөөнд ГХУС чиглэлээр хийх ажлыг тусган, хэрэгжүүлж ажиллажээ. 2015 онд ГХУС чиглэлээр 18 шалгалт, 17 хууль сурталчилсан мэдээлэл ярилцлага хийсэн, 1488 хүнийг хамруулж, радиод 1 удаа, сайтад 16 удаа, 2016 онд ГХУС чиглэлээр хамтарсан шалгалт 4, дангаараа 19 сумын ГХУССЗ ажлыг шалгаж, хууль сурталчилсан мэдээлэл, ярилцлага 24 удаа хийж 840 хүнийг хамруулж, радиод 1 удаа, телевизэд 3 удаа ярилцлага, прокурорын байгууллагын веб сайтад 6 удаа мэдээлэл нийтлүүлсэн, 2017 онд ГХУС чиглэлээр шалгалт 5, байгууллага иргэнд хууль сурталчилсан мэдээлэл, ярилцлага 25 удаа хийж 588 хүнийг хамруулж, радиод 1 удаа, телевизэд 4 удаа ярилцлага, Прокурорын байгууллагын веб сайтад 5 удаа мэдээлэл нийтлүүлж ажилласан байна.

ГХУСАЗЗ-өөс жил бүр сургалт, сурталчилгааны ажлын тасралтгүй байдлыг хангаж ажилладаг бөгөөд хууль хяналтын байгууллагууд нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг иргэдэд мэдээлэх, сурталчилах, сургалтыг тогтмол хийдэг байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр үр дүнтэй
байна уу?

Бүлэг 2

**Гэмт хэргийн гаралт буурахгүй байгаа нь гэмт хэргээс
урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр өнөөгийн
хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байгааг харуулж байна.**

*2.1 Гэмт хэргийн гаралт буурахгүй байгаа нь гэмт хэргээс урьдчилан
сэргийлэх ажлын арга хэлбэр өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байгааг
харуулж байна.*

ГХУСАЗЗ-өөс жил бүр тодорхой зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн, санхүүжилт батлуулан, сургалт, сурталчилгааны ажлын тасралтгүй байдлыг ханган ажиллаж, хууль хяналтын байгууллагууд нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг иргэдэд мэдээлэх, сурталчилах, сургалтыг хийж байгаа боловч *гэмт хэргийн гаралт буурахгүй байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байгааг харуулж байна.*

Аймгийн ГХУСАЗЗ-өөс гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомж болон бусад хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулахдаа зорилтот бүлэгт чиглэсэн, энгийн түвшинд ойлгохоор агуулгатай, сонирхолтой хэлбэрээр видео, теле зохиомж, жүжигчилсэн хэлбэрээр зохион байгуулах нь үр дүнтэй байна гэж үзсэн байна. Иймд шинээр батлагдсан Зөрчлийн тухай хуулийн аймгийн түвшинд ихээр бүртгэгдсэн зөрчлийн төрлүүдийг сонгон авч Монгол туургатай театрын мэргэжлийн жүжигчидтэй хамтран 10-15 минутын цуврал кино бэлтгэн аймгийн телевизүүдээр гаргахаар бэлтгэн ажиллаж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь дан ганц цагдаа, хууль хяналтын байгууллагуудын хийх ажил биш гэдгийг иргэдэд ойлгуулж, эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлөө бүрдүүлэх нь иргэн бүрийн оролцоо чухал гэдэг ойлголт хандлагыг суулгаж өгөх соён гэгээрүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах шаардлагатай байна.

*2.2 ГХУСАЗЗ нь аймаг, сумын ИТХ-ын дэргэд орон тооны бус бус зөвлөл
байгуулагдан хууль, хяналтын байгууллагуудтай хамтран өөрсдийн хуулиар
хүлээсэн чиг үүргийн дагуу ажиллаж байна.*

ГХУС тухай хуулийн 16 дугаар зүйлд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд Хууль зүйн сайдаар, аймаг, нийслэл, сум, дүүрэгт түүний иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн даргаар толгойлуулсан орон тооны бус зохицуулах зөвлөл зохицуулна” гэж заажээ.

*ГХУСАЗЗ нь аймаг, сумын ИТХ-ын дэргэд орон тооны бус бус зөвлөл
байгуулагдан хууль, хяналтын байгууллагуудтай хамтран өөрсдийн хуулиар
хүлээсэн чиг үүргийн дагуу ажиллаж байна.*

2.3 Гэмт хэргийн гаралт буурахгүй байгаа нь анхан шатны нэгж болох сумын ГХУСА33 тодорхой ажил хийхгүй байгааг харуулж байна.

Аймаг, сумын ИТХ-ын дэргэд орон тооны бус ГХУСА33 байгуулагдан ажиллаж байна. Аймгийн ГХУСА33 нь жил бүр тодорхой зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээгээ төлөвлөн, баталж, хэрэгжилтийг ханган ажилласан байна. Аймгийн ГХУСА33 болон хууль хяналтын байгууллагуудын ажлын тайлан, мэдээ, судалгаанаас харахад сумын ГХУСА33-үүд нь тодорхой хийсэн ажил байхгүй байна.

Гэмт хэргийн гаралт буурахгүй байгаа нь анхан шатны нэгж болох сумын ГХУСА33 тодорхой ажил хийхгүй байгааг харуулж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төсвийн
хөрөнгө үр ашигтай зарцуулагдаж байна уу?

Бүлэг 3

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт сурталчилгаа, арга хэмжээ зохион байгуулсан боловч тодорхой үр дүнд хүрэхгүй байгаа нь төсөв, санхүүжилтийг бүрэн төлөвлөөгүйтэй холбоотой байна.

3.1 ГХУС арга хэмжээнд 2015, 2016, 2017 онуудад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан хэмжээнээс дутуу төсөв баталсан байна.

Аймгийн ИТХ-аар ГХУС зардлын төсвийг 2015 онд 20.2 сая төгрөг, 2016 онд 39.2 сая төгрөг, 2017 онд 39.5 сая төгрөгөөр баталсан байна. Жил бүр сумдын ГХУС зардлын санхүүжилтэнд 0.9-6.0 сая төгрөгийг хувиарласан байна.

Аймгийн төсөвт буюу торгуулийн орлогын дансанд 2014 онд 141.2 сая төгрөг, 2015 онд 197.4 сая төгрөг, 2016 онд 214.4 сая төгрөг, 2017 оны эхний хагас жилд 128.6 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Гэтэл гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд өмнөх оны гүйцэтгэлээс 40 хувиар тооцоход 2015 онд 36.3 сая төгрөг, 2016 онд 39.8 сая төгрөг, 2017 онд 46.3 сая төгрөгөөр тус тус дутуу төлөвлөсөн байна.

Аймгийн ИТХ-ын 2015.12.04-ны 11 дүгээр хуралдааны 09 дугаар тогтоолоор аймгийн ИТХ-ын төсөвт Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 39.9 сая төгрөгийг баталсан боловч ГХУС арга хэмжээнд 20.2 сая төгрөг, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг хянах Иргэний зөвлөлд 19.7 сая төгрөгийг салган хуваарилсан байна. Мөн Аймгийн ИТХ-ын 2016.12.02-ны III-дүгээр хуралдааны 03 дугаар тогтоолоор аймгийн ИТХ-ын төсөвт Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 39.5 сая төгрөгийг баталсан боловч ГХУС арга хэмжээнд 20.2 сая төгрөг, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг хянах Иргэний зөвлөлд 19.3 сая төгрөгийг салган хуваарилсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт зааснаар “тухайн жилд шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял ногдуулж төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан дараагийн жилийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх” заалтыг үндэслэсэн боловч ГХУС арга хэмжээний төсвийг жил бүр дутуу төлөвлөсөн байна.

3.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт сурталчилгаа, арга хэмжээ зохион байгуулсан боловч тодорхой үр дүнд хүрэхгүй байгаа нь төсөв, санхүүжилтийг бүрэн төлөвлөөгүйтэй холбоотой байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт зааснаар “тухайн жилд шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний

болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял ногдуулж төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан дараагийн жилийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.6.2 дах хэсэгт “нутгийн захиргааны бүх шатны байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг өөрийн төсвөөс тусгайлан төлөвлөж санхүүжүүлэх”, 7.7 дах хэсэгт “Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн нутаг дэвсгэр дээр гарч байгаа гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцлийг арилгах талаар харьяа нутаг дэвсгэрт оршин байгаа аж ахуйн нэгж, байгууллагаас зохиож байгаа ажлыг хэлэлцэн чиглэл өгч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээг хянан батална” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажилласан байна.

ГХУСА33-ийн аймгийн хэмжээний төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл

Он	Төлөвлөгөө /сая төг/	Гүйцэтгэл /сая төг/	Зөрүү
2015 он	76.44	65.47	10.97
2016 он	93.8	89.0	4.8
2017.06.30	73.7	31.1	42.6
Нийт	243.94	185.57	58.37

Аймгийн ГХУСА33 жил бүрийн 1 дүгээр сардаа хуралдан үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвөө баталдаг байна. ГХУС арга хэмжээнд сүүлийн гурван жилд аймаг 20.2 сая төгрөгийг нэг жилдээ зарцуулахаар төлөвлөсөн байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн зөвлөлийн 2015, 2016, 2017 оны үйл ажиллагааны төсвийн зарцуулалтаас үзэхэд:

- ✚ Сумын ГХУСА33-ийн үйл ажиллагааны үр дүнг үндэслэн эхний 5-н байр эзэлсэн сум, зөвлөлийн дарга, Засаг дарга нарыг урамшуулсан
- ✚ Аймгийн ГХУСА33-ийн гишүүдийн үйл ажиллагааг үнэлж, урамшуулсан
- ✚ Архи хэрэглэдэггүй гэр бүл, байгууллагыг шалгаруулан урамшуулсан
- ✚ Тэргүүний мал хамгаалах “Малчдын бүлэг” шалгаруулан урамшуулсан
- ✚ Гэмт хэрэг хэв журмын зөрчилгүй сургууль шалгаруулан урамшуулсан
- ✚ Оны тэргүүний хуульч, эрх зүйч шалгаруулан урамшуулсан
- ✚ “Сайн хөрш”-ийн холбоог шалгаруулан урамшуулсан
- ✚ Нээлттэй хаалганы өдөрлөг, “Иргэдээ сонсоё” уулзалт, ЕБС-ийн сурагчдад хуулийн сургалт зохион багуулах
- ✚ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үүрэн холбооны үйлчилгээ эрхэлдэг байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж, мессеж үйлчилгээг нэвтрүүлэх
- ✚ Нийтийн эргүүл, урамшуулалтай эргүүл арга хэмжээг зохион байгуулах
- ✚ ГХУС ажлыг зохицуулах сумдын зөвлөлийн гишүүдийн нэгдсэн болон хэсэгчилсэн сургалт семинар зохион байгуулах
- ✚ Малчдын бүлгийн ахлагч, багийн Засаг даргын сургалт, семинарыг зохион байгуулах
- ✚ Гэр бүлийн хүчэрхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчлах сумдын хамтарсан багийг чадавхижуулах сургалт зохион байгуулах
- ✚ ЕБС-ийн сурагчдын дунд “Хуулиа дээдэлье” тэмцээн зохион байгуулах

Аймгийн ГХУСАЗЗ болон хууль хяналтын байгууллагатай хамтран ГХУС чиглэлээр зохиож буй ажлын талаарх мэдээллийг мэдээллийн хэрэгсэлээр олон нийтэд сурталчлах, тусгай нэвтрүүлэг бэлтгэн хүргэх ажлыг зохион байгуулах гэсэн арга хэмжээнүүдийг жил бүр зохион байгуулж санхүүжилтийг олгосон байна.

Аймаг сумдын ГХУСАЗЗ нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, Гэр бүлийн хүчэрхийлэлтэй тэмцэх, Замын хөдөлдөгөөний дүрэм, Архидан согтуурахтай тэмцэх, Хүүхдийн эрхийг хамгаалах, Байгаль хамгаалах, Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, Цахим гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт сурталчилгаа, арга хэмжээ зохион байгуулсан боловч тодорхой үр дүнд хүрэхгүй байгаа нь төсөв, санхүүжилтийг бүрэн төлөвлөөгүйтэй холбоотой байна.

3.3 ГХУС арга хэмжээнд зарцуулагдсан хөрөнгийн ихэнхи хувийг сургалтын хоол, тэмцээн уралдааны шагналд зарцуулсан байна.

Аймгийн ГХУСЗЗ-ийн зардлын судалгааг аймгийн ИТХ, 27 сумын ИТХ-аас гаргуулан нэгтгэхэд дараах чиглэлээр зарцуулсан байна.

Арга хэмжээ	2015 он	2016 он	2017 он	Нийт
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хууль сахиулах байгууллага, төрийн бус байгууллагуудаас иргэд, байгууллагын дунд зохиож байгаа сургалт, сурталчилгааны зардлыг санхүүжүүлэх	35.13	45.4	14.68	95.21
Эргүүл, жижүүр, олон нийтийн цагдаагийн ажилтныг урамшуулах	11.8	9.2	5.42	26.42
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг шагнаж, урамшуулах;	5.6	10.9	2.1	18.6
Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд шаардлагатай техник, хэрэгслийн зардлыг санхүүжүүлэх	1.48	9.8	4.66	15.94

Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа болон үйлдсэн тухай цагдаагийн байгууллага иргэдээс мэдээлэл авах төлбөрийн зардлыг санхүүжүүлэх	3.15	2.8	0.64	6.59
Бусад	8.31	10.9	3.6	22.81

2015, 2016, 2017 онд нийт 243.94 сая төгрөг ГХУС зардалд хувиарласнаас 185.57 сая төгрөгийг зарцуулсан байна. ГХУС зардлын зарцуулалтын судалгаанаас харахад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хууль сахиулах байгууллага, төрийн бус байгууллагуудаас иргэд, байгууллагын дунд зохиож байгаа сургалт, сурталчилгааны зардлыг санхүүжүүлэх зардалд 51.3 хувийг, Эргүүл, жижүүр, олон нийтийн цагдаагийн ажилтныг урамшуулах зардалд 14.2 хувийг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг шагнаж, урамшуулах зардалд 10.1 хувийг, Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд шаардлагатай техник, хэрэгслийн зардлыг санхүүжүүлэх зардалд 8.6 хувийг, Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа болон үйлдсэн тухай цагдаагийн байгууллага иргэдээс мэдээлэл авах төлбөрийн зардлыг санхүүжүүлэх зардалд 3.6 хувийг, Бусад зардалд 12.2 хувийг зарцуулсан байна.

ГХУС зардлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т заасан чиглэлийн дагуу зарцуулдаг боловч сургалт семинарын хоол, уралдаан тэмцээний шагнал, томилолт, шатахууны зардалд ихэнхи хувийг зарцуулсан байна. Мөн Цагдаагийн байгууллагын дутагдалтай зардлыг санхүүжүүлэх байдлаар зарим зардлууд гарсан байна. Иймд ГХУС зардлыг зохицуулах тусдаа журам гаргах шаардлагатай байна.

Аймаг орон нутгаас жил бүр ГХУС зориулалтаар хөрөнгө шийдвэрлэж ажилласан байна.

2015 онд:

-Гудамж талбайд гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх таслан зогсоох, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх зорилгоор Зуунмод суманд 249.0 сая төгрөгийн гудамж, талбайн хяналтын камерийг суурилуулсан.

-Мөнгөн торгуулийн шийтгэлийг бэлэн бус хэлбэрээр оногдуулах боломжийг бүрдүүлж цагдаагийн шалгах төхөөрөмж "POLICE READER" багажаар Лүн, Баянчандмань, Зуунмод сумдын цагдаа зохицуулагч нарт өгсөн.

-Цагдаагийн хамгаалалтын зардалд 3.6 сая төгрөг шийдвэрлэж өгсөн.

2016 онд:

-Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх чиглэлээр 2.0 сая төгрөгийн шатахуун,

-Баяр наадмын хамгаалалтанд ажилласан Цагдаагийн албан хаагчдад 3.8 сая төгрөгийн хоол, шатахуун,

-Аймгийн ГХУСАЗЗ-өөс Замын цагдаагийн тасгийн үйл ажиллагаанд шаардлагатай 1.6 сая төгрөгийн гэрэлт самбар,

-Замын цагдаагийн тасаг, Нийтийн хэв журам хамгаалах тасагт хөдөлгөөнт эргүүлийн авто машин тус бүр 1, шулуун замд хэрэг шалгах, байцаан шийтгэх

ажиллагаа явуулахад шатахуун бага зарцуулах машин 1, нийт 62.5 сая төгрөгийн 3 суудлын автомашин,

-Замын цагдаагийн тасагт бэлэн бус торгуулийн тасалбар уншигч нийт 62.0 сая төгрөгийн "POLICE READER" багаж 30 ширхэг,

-Олон нийтийг хамарсан арга хэмжээ, хамгаалалтын үер ашиглах 4.0 сая төгрөгийн "DRONG" нисдэг камер,

-Цагдаагийн газрын холбоо мэдээллийн шуурхай, тасралтгүй байх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор 25 ширхэг 2.5 сая төгрөгийн гар станц авах хөрөнгийг тус тус шийдвэрлэж өгсөн байна.

2017 онд:

Аймгийн "Нэгдсэн эмнэлэг"-ийн амбулаторийн цахим бүртгэлийн хэсэгт хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн ГХУСА33-өөс 2.5 сая төгрөгийн өртөг бүхий хяналтын 5 телекамер,

-Цагдаагийн газрын мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, зам тээврийн осол зөрчил, бусад төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 12.5 сая төгрөгний төсөвт өртөгтэй явуулын пост ажиллуулах чиргүүл,

-Сэргэлэн сумын "Өндөр-Дов" гэх газарт Замын цагдаагийн байнгын ажиллагаатай 40.0 сая төгрөгийн постын барилга,

-Гэр бүлийн хүчэрхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, гэр бүлийн хүчэрхийлэлд өртсөн иргэдийг хамгаалалтанд авах зориулалтын "Түр хамгаалах" байрыг шинээр бий болгон Цагдаагийн газрын Б байранд засварлаж тохижуулсан зэрэг хөрөнгүүдийг шийдвэрлэж өгсөн байна.

Аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

-Сургалт семинарын үеэр нилээд их хэмжээний хоолны зардал гарсан байна. 2015 онд 6.7 сая төгрөг буюу нийт төсвийн 33.2%, 2016 онд 5.9 сая төгрөг буюу нийт төсвийн 29.2%, 2017 онд 3.3 сая төгрөг буюу нийт төсвийн 16.3%-ийг хоолонд тус тус зарцуулсан.

-Тэмцээн уралдааны шагналд 2015 онд 4.4 сая төгрөг буюу нийт төсвийн 21.7%, 2016 онд 10.5 сая төгрөг буюу нийт төсвийн 52%, 2017 онд 1.0 сая төгрөг буюу нийт төсвийн 4.9%-ийг тус тус зарцуулсан нь нийт төсвийн ихэнхи хувийг энэ хоёр төрлийн зардалд зарцуулсан байна.

-Төлбөрийн актын 75.0 мянган төгрөгийг хувь хүмүүсээр төлүүлэх байсныг ГХУС зардлаас төлсөн.

-Аймгийн ИТХ-ын албаны машинд 88.0 мянган төгрөгийн сэлбэг авч өгсөн.

-Аймгийн ИТХ-ын 2015 оны 11 дүгээр хуралдааны хоолны зардал 2.7 сая төгрөгийг ГХУС зардлаас зарцуулсан байна. Энэ нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4-т " Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Орон нутгаас шийдвэрлэсэн хөрөнгүүдээс Зуунмод суманд 2015 онд тавигдсан гудамж талбайн хяналтын камерийн 249.0 сая төгрөгийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдсан байна. 27 камер ажиллахаас 24 камер нь ажиллахгүй, 3 камер ажиллаж байна.

3.4 Аймгийн ИТХ-аас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлын зарцуулалтанд хяналт тавьсан талаар тайлан байхгүй байна.

Аймгийн ГХУСАЗЗ-ийн үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр Хууль зүйн яаманд хүргүүлдэг, Аймгийн ИТХТ-ийн хуралдаанаар ГХУСАЗЗ-ийн үйл ажиллагааны тайлан, санхүүгийн зарцуулалтын тайланг жилийн эцсээр нэг удаа хэлэлцдэг байна. Аймгийн ИТХ-аас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлын зарцуулалтанд хяналт тавьсан талаар тайлан байхгүй байна. Энэ нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5-д “хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд орон нутгийн ИТХ болон төсвийн хууль тогтоомжид заасан эрх бүхий этгээд хяналт тавьна” гэсэн заалт бүрэн хэрэгжихгүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

1.Аймгийн хэмжээнд согтуугаар үйлдсэн гэмт хэрэг, өмчлөх эрхийн эсрэг хулгайн гэмт хэрэг нийт гэмт хэргийн дийлэнх хувийг эзэлж байгаа нь газар нутгийн онцлогоос шалтгаалж байна.

2. Аймгийн ИТХ-ын дэргэдэх ГХУСА33 нь жил бүр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор тодорхой зорилтууд, хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлж, жил бүрийн төсөвтөө тодорхой хэмжээний санхүүжилтийг батлан ажиллаж байна.

3.Аймгийн ГХУСА33, төрийн болон хууль хяналтын байгууллагууд нь иргэд болон ТББ-тай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллаж, зарим ТББ-дад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.

4.Гэмт хэргийн гаралт буурахгүй байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байгааг харуулж байна.

5.Гэмт хэргийн гаралт буурахгүй байгаа нь анхан шатны нэгж болох сумын ГХУСА33 тодорхой ажил хийхгүй байгааг харуулж байна.

6. ГХУС арга хэмжээнд 2015, 2016, 2017 онуудад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан хэмжээнээс дутуу төсөв баталсан байна.

7.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт сурталчилгаа, арга хэмжээ зохион байгуулсан боловч тодорхой үр дүнд хүрэхгүй байгаа нь төсөв, санхүүжилтийг бүрэн төлөвлөөгүйтэй холбоотой байна.

8.ГХУС арга хэмжээнд зарцуулагдсан хөрөнгийн ихэнхи хувийг сургалтын хоол, тэмцээн уралдааны шагналд зарцуулсан байна.

9.Аймгийн ИТХ-аас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлын зарцуулалтанд хяналт тавьсан талаар тайлан байхгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн аймгийн ГХУСА33-ийн дарга Ц.Энхбат, аймгийн Прокурорын газрын дарга С.Алимаа, Цагдаагийн газрын дарга Б.Ганзориг нарт зөвлөх нь:

1. Гэмт хэргийн гаралт буурахгүй байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байгааг харуулж байна. Иймд гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомж болон бусад хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулахдаа зорилтот бүлэгт чиглэсэн, энгийн түвшинд ойлгохоор агуулгатай, сонирхолтой хэлбэрээр зохион байгуулах.

2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах анхан шатны нэгж болох сумын ГХУСА33-ийн ажлыг идэвхижүүлэх ажлыг зохион байгуулах.

3. ГХУС арга хэмжээнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан хэмжээгээр төсвийг батлах

4. ГХУС арга хэмжээний зардлын зарцуулалтын журам боловсруулж мөрдөх, хэрэгжилтэнд нь аймаг, сумын ИТХ-аас хяналт тавих

Холбогдох байгууллагын санал


**ТӨВ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧИД**
41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70273003, факс: 70272354

2017.10.25 № 319

танай _____ -ны № _____ -т

**ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА Ц.ХИШИГЖАРГАЛ
ТАНАА**

Үндэсний Аудитын газрын нэгдсэн удирдамжаар хийгдсэн "Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн" сэдвээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Гүйцэтгэлийн аудитын дүгнэлтэнд тусгайлан өгөх санал байхгүй бөгөөд аудитын тайланг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн холбогдох байгууллагуудад ажлын чиглэл өгч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж ажиллах болно.

ДАРГА  Ц.ХИШИГЖАРГАЛ

0100319

My doc:- /2017 on /A5 toot



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ ТАНАА

2017.10.24 № 51/03-4069
таний 2017.10.27-ны № 11474 -Т

Хариу хүргүүлэх тухай

Танай байгууллагаас ирүүлсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр ҮАГ-ГАГ/2017/09-ГА сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцаад дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

-Төв аймгийн ГХУСА33-с гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зөвлөгөөн, уралдаан тэмцээн зохион явуулах төдийхнөөр урьдчилан сэргийлэх ажил явагдаж байгаа нь учир дутагдалтай байна.

-ГХУСА33-ийн жилийн төсөв нь иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулахад урамшуулах төсөв байдаггүйгээс иргэдийн идэвх оролцоо муу байдаг,

-ГХУСА33-с бодитой ажил бага хийгдэж байна. Тухайлбал сургууль, цэцэрлэгийн орчныг аюулгүй байлгах, авто замын тэмдэг тэмдгэлгээ, гарц зэрэг зайлшгүй шаардлагатай ажлуудын төсөв хөрөнгийг ГХУСА33-ийн төсөвт тусгаж бодитой ажил хийж гүйцэтгэж байх.

-Аймаг, орон нутгийн хэмжээнд гэмт хэргийг гаралт их байгаа нь газар нутгийн онцлог, хүн амын суурьшил, авто зам, төмөр зам, харилцаа холбоо өргөн хөгжсөн, зах зээлд ойрхон зэрэг нийгмээс шалтгаалах олон хүчин зүйл нөлөөлж байна. Гэмт хэргийг үйлдэгдсэн хойно нь биш үйлдэгдэхээс нь өмнө урьдчилан сэргийлэх ажлыг бодитой үр дүнтэй болгох нь чухал.

Иймээс цагдаагийн байгууллагын хүн хүч, техник хэрэгсэл, хөдөө орон нутаг, сум, багийн хэмжээнд ажиллах алба хаагч, тасаг хэсгийн тоог нэмэгдүүлэх нь чухал байна.

ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ТАСВИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Г.ЭРХЭМБАЯР



51000866


**ТӨВ АЙМГИЙН
ПРОКУРОРЫН ГАЗАР**
41100 Зуунмод, Төв аймаг
Утас/факс: 70273977, И-мэйл: tuv@prokuror.mn

2017.10.2 № 5/1016
тантай _____-ийн _____-т

**ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.ХИШИГЖАРГАЛ ТАНАА**

Үндэсний Аудитын газрын нэгдсэн
удирдамжаар хийгдсэн "Хууль сахиулах
байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
чиг үүргийн хэрэгжилт, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн
аудитын тайланд оруулах саналгүй болно.

ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ОРЛОГЧ
ХУУЛЬ ЦААЗЫН АХЛАХ
ЗӨВЛӨХ

Ц.СОНИНМӨНХ

000 0724